

ОРХОН-ЕНИСЕЙН БИЧЭЭСИЙН ТАЙЛАЛ¹

170 гаруй жилийн өмнө өмнөд Сибирьт, Енисей мөрний эх орчимд урьд өөр хаа ч үзэгдээгүй үсэг, үл мэдэгдэх хэлээр бичигдсэн бичээсүүд олдсоныг бид мэдэх билээ. И.Р.Аспелинаар удирдуулсан нэр бүхий шинжилгээний ангийн хийсэн судалгааны үр дүн болох, “Inscriptions de l'énissei: recueillies et publiées par la Société finlandaise d'archéologie” (Хельсинк, 1889) хэмээх үнэт судалгааны ачаар сүүлийн жилүүдэд тэрхүү гайхалтай бичээсүүд илүү өргөн хүрээнд, тодорхойёо тайлагдаж эрдэмтэн судлаачдад хүрсэн юм. 1892 онд профессор О.Доннер дээр нэр дурдагдсан судалгаанд нэмэрлэн “Wörterverzeichnis zu den Inscriptions de l'énissei” (Mémoires de la Société Finno-Ougrienne IV) хэмээх дургалаа нийтлэв. Енисейн бичээс нь хэл шинжлэл, археологийн эрдэмтэн судлаачдын дунд шуугиан дэгдээсэн бол Монголын умард нутаг, Орхоны хөндий, эртний хот Хархорин, Хар балгасын орчмоос олдсон удаах нээлтүүд эрдэмтэн судлаачдыг бүр ч цочроосон юм. Учир нь тэдгээр нээлт Енисейн бичээстэй гарал нэг, бүр ч сүрлэг хөшөө дурсгал оршин буйг баталсан билээ. Тэндээс олдсон дурсгалууд дахь үсэг Енисейн бичээс дэхтэй бараг адилхан бөгөөд бичигдсэн хэл нь ч Енисейн бичээсийнхтэй яв цав нийлэхгүй юм гэхэд гарал ойр гэхүйц аж.

Энэхүү гайхалтай нээлтүүд, нэг талаас, 1890-1891 онд дээр дурдагдсан газруудад очиж судалсан Финландын эрдэмтэн А.Гейкелийн ач гавьяа, нөгөөтээгүүр мөн Хаант Оросын Засгийн газраас 1891 оноос эхлэн алдарт түрэг судлаач эрдэмтэн В.Радловын удирдлага дор илгээсэн эрдэм шинжилгээний удаа дараагийн экспедицийн ач гавьяа билээ.

Эдгээр экспедицийн үр дүн дараах: 1) “Inscriptions de l'Orkhon, recueillies par l'expédition finnoise 1890 et publiées par la Société Finno-Ougrienne” хэмээх хосгүй бүтээлд, 2) түүнээс дутахгүй алдаршсан 1892 онд Санкт-Петербургт хэвлэсэн “Atlas der Alterthümer der Mongolei. Im Auftrage der Kaiserl. Akademie der Wissenschaften herausgegeben von Dr. W.Radloff” хэмээх газрын зураг, зургийн цомогт тус тус нийтлэгджээ. Дээрх бичээсүүдийн эхийг хэрхэн буулгасан байдлыг үзвэл, үнэнийг хэлэхэд, энэ хоёрын хооронд зөрүү гарах үед би Радловын хүснэгтэлсэн зургуудыг² бус, Фин-Угорын нийгэмлэгийн дардас ашиглан буулгасныг илүүд үздэг. Ямартай ч харьцуулах зорилгоор ашиглахад аль аль нь гар дор байх шаардлагатай юм. Хэдий эдгээр бүхий байгаа ч гэлээ олон хэсэг нь эргэлзээтэй хэвээр учир тэдгээр бичээсийг тайлж унших түлхүүрийг олсон цагт шинээр ул суурьтай судалгаа хэвлэгдэн гарваас туйлын хэрэгтэй билээ. Дээр дурдсан өгүүлүүдийн тухай цааш дэлгэрүүлэн өгүүлэхийн өмнө, “Inscriptions de Orkhon”-д I, II хэмээн тэмдэглэгдсэн болон Радловын тодруулсан зургийн эмхэтгэлд K, X хэмээн тэмдэглэгдсэн хоёр гэрэлт хөшөөг голчлон авч үзнэ гэдгээ онцолъё. Тэдгээрээс илүү, эсхүл арай бага ач холбогдолтой олон бичээс буй бөгөөд үргэлжилсээр буй хайгуул судалгааны дүнд цаашид ч ийм олон дурсгал олдох төлөвтэй байна. Өмнө дурдагдсан хоёр том гэрэлт хөшөөний I = K нь давгүй хадгалагдаж үлдсэн бол II = X нь нэлээн гэмтэж

¹ П.Номинбилэг. МУИС-ын Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийн 2019-2021 оны магистрант мэргэжлийн магистрын хөтөлбөрийн дадлага ажлын хүрээнд орос хэлнээс орчуулав. Франц эх нь: *Dechiffrement des inscriptions de l'Orkhon et de l'énissei. Notice préliminaire par Vilh. Thomsen* нэрээр анх хэвлэгджээ.

² Энэхүү “Атлас”-т томоохон бичээсүүдийн тодруулаагүй хувилбарууд ч бий.

эвдэрсэн ажээ. Руни үсгээр бичигдсэн, багагүй урт бичээсээс гадна, дөрвөн талынх нь нэг дээр хятад хэлээрх бичээс буй. I хөшөөний хятад бичээсийн тухай Георг Габеленц ихээхэн эшлэгдсэн өгүүллийнхээ 15-16-р хуудсанд, дараа нь Нидерландын хятад судлаач эрдэмтэн Г.Шлегель “La Stèle Funéraire Du Teghin Giogh” (Фин-угорын нийгэмлэг, Хельсинк 1892) дуртгалдаа илүү тодорхой, дэлгэрэнгүй тайлбарласан байдаг учир “Inscriptions de Orkhon” дахь тайлбарыг орхиё.

Тэнд, түүнчлэн Хятадын түүхчдийн тайлбарласнаар, уг хөшөөг Кюэ ти(к)-кин буюу ханхүү (түрэгээр “тигин”) Кюэ (зөв хувилбарыг нь доороос үзнэ үү), Кот-толук ко-хан буюу хаан Кутлук (түрэгээр Кутлук гэдэг нь *жаргалтай* гэсэн утгатай)-ийн хүү, тухайн үед хаан ширээг эзэгнэж асан хааны бага дүү, энд Пу(т)-kia ко-хан нэрээр бичигдсэн (бусад эх сурвалжид Мики-лянь, Могилан, Могилэн гэх зэргээр тэмдэглэгдсэн байдаг) эрийн дурсгалд зориулжээ.

Бичээст Христийн тооллын өмнөх 733 оны нэгдүгээр сарын 28-ны өдрийг тэмдэглэсэн байдаг. Ханхүү Кюэ VI зууны хоёрдугаар хагасаас буюу угсаа гарал нэгтэй уйгуруудад эзлэгдсэн үеэс энэ хязгаарыг эзэгнэсэн Тү-кюэ буюу Туркийн эзэнт гүрний хүн байсан хийгээд 731 онд өөд болсон гэдгийг бид Хятадын түүхэн сурвалжаас мэднэ.

Хоёрдугаар хөшөө нэгдүгээр хөшөөтэй бараг нэг цаг үеийнх, түүнчлэн бичээсийнх нь олон хэсэг I хөшөөнийхтэй ав адил буюу адил шахам. Эл хөшөөг нэгдүгээр хөшөөний тухай хэсэгт дурдсан ханхүү буюу 734 онд тэнгэрт хальсан хаан Могилян (Билгэ хаан)-ы дүүд зориулан босгосон гэдгийг бид бат мэднэ.

Түүхэн ач холбогдол хийгээд гарал үүслийн хувьд эдгээр хөшөө ямар учиртай гэдэг нь харьцангуй тодорхой болсон ч дээр хэлсэнчлэн үл мэдэгдэх үсгээр бичигдсэн бичээсийнх нь нэлээд хэсэг нь одоо ч тайлагдаагүй байгаа юм. Энэ өгүүлэлдээ бид тэрхүү бичээсүүдийн тухай ярих болно.

Энэхүү бичээсүүд нь хятад бичгийнхээ адил босоо хэлбэрээр бичигдсэн бөгөөд тиймдээ үсэг нь толгой нь урагш, хөл нь хойш налсан мэт харагдана. Доороос дээш биш, хятад, монгол бичгийн адил дээрээс доош унших ёстой гэдэг нь илэрхий. Үүнийг өөр судлаачид ч баталсан байдаг. Өөрөөр хэлбэл, бид мөрүүдийг нь хэвтүүлж, үсгүүдийг нь босоо болгож харвал, түүнийгээ баруунаас зүүн тийш унших ёстой гэсэн үг гэдгийг давгүй хадгалагдаж үлдсэн III хөшөөний нүүр дээрх бичээс (“Inscriptions de L’Orkhon”-ийн 46 дугаар хүснэгт = Радловын “Атлас”-ийн XXXV хүснэгт), мөн Енисейн зарим бичээсээс харж болох юм.

Гэвч энд өөр нэг асуулт урган гарч ирнэ. Босоо мөрүүд өөр хоорондоо ямар зүй тогтлоор байршиж байна вэ? Өөрөөр хэлбэл, хятад хэлний адилаар баруунаас зүүн рүү унших уу, эсхүл монгол хэлний адил зүүнээс баруун тийш унших уу? “Inscriptions de L’Orkhon”-д ч тэр, Радловын “Атлас”-т ч тэр, сүүлийнх нь тогтолцоог баримталжээ. Жишээ нь I хөшөөний баруун талыг харвал хоёр судалгаанд хоёуланд нь зүүн талаас нэгдүгээр мөр хэмээж (1. 1) дугаарлаж, баруун талаас дөчдүгээр (1. 40) мөр хэмээн дугаарласныг харж болно. Мөр болгоныг нь энгийн байдалд (хэвтээ байрлалд) оруулаад хамгийн баруун талын мөрийг эхний мөр хэмээн үзвэл удаах мөр нь сүүлчийн гэгдэж буй мөрийнхөө дээр, удаах нь мөн дээр нь гэх байдлаар байрлах хачин үзэгдэл тохионо гэх үндэслэлийн (“Inscriptions de L’Orkhon”, XLIII болон G.Huth, “Die Inschrift von Karakorum”, Берлин 1892, 20-21-р хуудас) дагуу л ингэж үзсэн бололтой. Үнэндээ бол энэ үндэслэл огтоос ач холбогдолгүй юм. Бичээсүүдийн маань мөрүүд босоо учир дээд, доод мөр гэж ярих нь илүүц билээ. Энэ бол гагц бидний хувийн сэтгэгдэл бөгөөд өөрсдөдөө эвтэйхэн болгохын тулд л хөндөлдүүлэн төсөөлж, баруунаас зүүн тийш уншсан хэрэг. Үүний оронд, бидэнд энэ асуудлыг нэгмөсөн шийдэх хялбар арга бий. Тэрхүү арга бол хоёр бичээсийн параллель мөрүүдийг нарийн харьцуулах. Дээрх судалгааг эрхлэн гаргагчид энэ аргыг хэрэглээгүйн учир нь, нэг талаас, О.Доннерын (“Inscriptions de L’Orkhon”, XLVI) бичсэн мөнөөх үндэслэл, нөгөө талаас, параллель хэсгүүдийг харьцуулсан хүснэгтийг хийхдээ ашигласан арга хэрэглүүр нь анхнаасаа хоёр бичээсийн ялгааг анхааралтай шинжээгүйг харуулж байгаа юм. Жишээ нь бид

I-18, II-23-ийг зэрэгцүүлж харьцуулаад, дараа нь I-19-ийг II-24, 22-тэй харьцуулбал параллель мөрүүд дэх үгс хачирхалтайгаар солигдсоныг гайхна. Харин сүүлээс нь эхэлбэл байдал тэс өөр. I-40-ийн эхлэлийг бид II-40-ийн эцсээс (II-41 болон II-40-ийн дийлэнх хэсэг нь I хөшөөнийхтэй нийцдэггүй). I-40-ийн үлдсэн хэсэг нь II-39-ийн нэгдүгээр хагастай үг нэг бүрчлэн нийлж байхад II-39-ийн үргэлжлэл нь I-39, I-39-ийн төгсгөл нь II-38-ийн эхлэлтэй нийлж байна. Цөөн газарт, дүрслэлийн зөрүүнээс болж өөр буйг эс тооцвол, энэхүү бүрэн давхцал цааш ч үргэлжлэх бөгөөд II-18-тай ижил I-11 хүртэл ажиглагдана. Эндээс эхлэн нарийн давхцал нь ховордож иржээ. I-64-өөс I-44-ийн дунд хүртэлхийг (хөшөөний өмнөд тал) мэдэгдэхүйц гэмтэж арилсан II-77-70 (хөшөөний умард тал) хэсэгтэй харьцуулахад дээрх тогтол илэрч буй. Эдгээр параллель хэсгүүдийн арилсан хэсгүүдийн бичвэрийг сэргээж, олон хэсгийн дутууг нөхөх чухал арга зам бидэнд бий. Энэ үндэслэлээс хөшөөний мөрүүдийг хятад хэлний адилаар баруунаас зүүн тийш унших нь зөв гэдэг дүгнэлт эргэлзээгүй гарч ирж байна. Иймд I хөшөөний баруун талын бичээс үнэн хэрэгтээ дээрх судалгаанд дөчдүгээр хэмээн дугаарлагдсан мөрөөс эхэлж байгаа бөгөөд нэгдүгээр хэмээн дугаарлагдсан мөр үнэндээ бол дөчдүгээрх³ юм.

Үүнийг батлах өөр нэг нөхцөл байгаа нь юу гэвэл, II хөшөөний өмнөд тал (“Inscriptions de L’Orkhon”-ийн 30-р хүснэгт = Радловын “Атлас”-ийн XXIV хүснэгт) дээрх бичээсийн 45, 46 дугаарх мөрүүдийн (= Радловын 3-4-р мөр) хооронд үсэг бичигдээгүй, хоёр хэсгийг заагласан гэж мэдэгдэхүйц том зай байгаа явдал. Үүний зэрэгцээ, 46-р мөр нь мөрийн уртыг голлож төгссөнийг харахул, хоосон зайгаар өндөрлөж буй тэр хэсгийнхээ төгсгөл нь бололтой байдаг. Харин 45-рх мөр нь 41, 77 дугаар хуудас = I-54 (хааны хэргэм зэрэг)-ны шинэ хэсэг эхлүүлж буй үгсээс эхэлж байгаа нь илэрхий байна. Энэ дагуу мөрүүдийн байрлалыг ингэж зураглаж болох юм:

s	d	a
h	e	b
i	f	c

Бичээс хөшөөний яг аль талаас эхэлж байгаа тухайд гэвэл, хоёр хөшөөний хоёулангийнх нь баруун талд ч, I хөшөөний өмнөд тал, агуулгаараа түүнтэй зэрэгцэж ирэх II хөшөөний хойд талд ч шинэ мөрүүд эхэлж байгаа нь тодорхой ажиглагдаж байгаа учир үүнийг мэдэх нь тийм ч чухал биш гэж хэлэх нь зүй. Энэ бүхнээс баруун талын өргөн хэсэг голлож байгаа нь харагдах бөгөөд тэндээс л бичээсийнхээ эхлэлийг эрэх нь зүйтэй гэж би үзэж байгаа болно.

Енисейн, Орхоны бичээсүүдийг тайлахаар өнөөг хүртэл хийсэн оролдлогуудын аль нь ч онц үр дүнд хүрээгүй юм. Тэгээд ч тэд ямар нэг яс тодорхой, баталгаатай арга барилгүй байв. Тэд энэхүү хачирхалтай үсгүүдийг хооронд нь болон өөр бичиг үсгийн зарим үсэгтэй дан үзэгдэх байдлаар нь зэрэгцүүлж нийцүүлж судалсан аж. Ноён О.Доннер өөрөө ч “Inscriptions de L’Orkhon”-ны эхэнд, XLIII болон удаах хуудсанд, түүнчлэн тэрхүү судалгаанаас өмнө нийтэлсэн жижгэвтэр өгүүллүүдээ тэр аргыг баримталж, үл мэдэгдэх тэрхүү үсгүүд Грек, Бага Азийн бичиг үсэгтэй адилхан хэмээн батлахыг хичээж байв. Гэвч сүүлд дурдсан хоёр нь манай бичээсээс 1000 орчим жилийн эсвэл бүр ч их хугацааны өмнөх гэдгийг мартаж болохгүй. Энэ мэтийн давхцал нь оптикийн хуурмаг үзэгдэл аятай зүйл гэдгийг хатуу санах хэрэгтэй. Үл мэдэгдэх эл бичгийн агуулгыг өөр аргаар тайлж чадсан цагт л энэ мэтчилэн өөр бичиг үсэгтэй харьцуулан судалж, үүсэл гарлыг нь тодорхойлох нь утга учиртай байх болно.

Енисейн бичээсүүдийг тайлахад нэн бэрх, туйлын эргэлзээтэй учир эхэндээ дан Орхоны бичээсүүдийг барих шаардлагатай. Түүгээр ч зогсохгүй, Орхоны бичээс байгаагүй бол Енисейн бичээсүүдийг хэзээ ч тайлж уншиж чадахгүй байх байсан гэж би итгэлтэйгээр батлан хэлж чадна. Тайлах явцад бидэнд түшиг болж буй тулгуур гэвэл I. ердөө энэ бичээсүүд

³ Ноён Радлов 1893 оны арваннэгдүгээр сарын 22-нд (арванхоёрдугаар сарын 4-нд) надад илгээсэн захидалдаа мөн ижил зүйл ажигласан, дахин хэвлэхдээ шинэчилсэн мөрийг нь зөв дарааллаар оруулна гэж бичсэн.

өөрсдөө: тэмдэг, эсвэл үгсийн текст дэх орчин нөхцөл, мөн л тэдгээр үгийн олон хувилбартай бичлэг зэрэг баримтууд юм. 2. Хятад бичээсийн тухай дүгнэлтүүд. Хятадаарх бичээсүүдийг харахад, бусад эрдэмтдийн баталсанчлан, бидний өмнө байгаа энэхүү дурсгал энгийн нэг хоёр хэл дээрх дурсгал биш гэдэг нь илхэн харагддаг. Юун түрүүнд, мөрийн дундаж уртыг нь харахад үл мэдэгдэх үсгээр бичсэн бичээс хятад бичээсээс даруй 4 юм уу 5 дахин урт байгаа юм. Хоёрдугаарт, хятад бичээсийнх нь үе бүтэц болон онцгой шинж чанарууд нь энэхүү хоёр хэлээрх бичээс огтоос хамааралгүй, бие даасан агуулгатай болохыг онолын хувьд ч, бодитоор ч баталж байна⁴.

Дээр дурдсан арга хэрэглүүрийг ашиглан би өнөөг хүртэл ойлгогдож өгөхгүй байсан тэрхүү нууцлаг үсгийг бүрэн тайлж чадсан гэж бодож байна. Ямар замаар явсан хийгээд ямар үр дүнд хүрснээ товчхон өгүүлсү.

Нийт, илүү ч үгүй дутуу ч үгүй 38 онцгой тэмдэгтэй, учир нь 39 тэмдгийн нэг, тодруулбал **L** нь өөр тэмдэгтэй, тодруулбал 7 юм уу 13 дугаархтай (179-р хуудсыг харах) андуурагдсан гэж би үзэж байгаа юм. Өмнө дурдсанчлан, үгсийг ихэвчлэн давхар цэгээр зааглана, гэхдээ үргэлж биш. Богино үгс, төлөөний нэр болон тооны нэр зэрэг нь ихэнх тохиолдолд нэг бол ардах, үгүй бол өмнөх үгтэй залгагдаж буй. Үүнээс үүдэлтэйгээр зарим судлаач (тухайлбал Huth, дээр 175-р хуудсанд эшлэгдсэн) Енисей-Остяцкийн хэлнийх шиг угтвар, дагаврын тусламжтайгаар бүтдэг өвөрмөц дайвар үг гэж үзэхэд хүрсэн нь бий. Доннер (“Inscriptions de L’Orkhon”, XLVIII), Радлов (“Атлас”-ын өмнөх үг) нар тэр дүгнэлтийн эсрэг зогссон юм.

Олон тэмдэг элбэг байгаагаас энэхүү нууцлаг бичиг нь авиа бүрийг тодорхой дүрсээр тэмдэглэдэг энгийн нэг цагаан толгой биш, нэг бол үечилсэн цагаан толгой, эсвэл нэг авиаг илэрхийлсэн тэмдгүүд тэр авиаг агуулсан янз бүрийн хэрэглээг даган тодорхой зүй тогтлоор хувирдаг гэж үзэх үндэслэл болж байна.

Юун түрүүнд би эгшиг үсгийг тэмдэглэсэн тусгай тэмдэг байна уу гэдгийг тогтоохыг зорьсон бөгөөд энэ талаар хялбархан амжилт олов. Энэ асуудлыг шийдэхийн тулд би эхлээд ХУХ гэдэг тэмдгийн хоршилд, өөрөөр хэлбэл ижил тэмдэг нэг тэмдгийн хоёр талд байгаа тохиолдолд У нь эгшиг үсэг, Х нь гийгүүлэгч, эсвэл эсрэгээрээ байх магадлал өндөр гэж үзсэн юм. Тийм хоршлуудыг бүтээж байгаа тэмдгүүдийг нь нямбай харьцуулж үзэхэд, басхүү бидний гар дор арвин их материал буй учир, эгшиг үсгийг олж таних нь амархан бөгөөд найдвартай байв. Ийнхүү би аль дээр л **У, Х, N** тэмдгүүд нь эгшиг болохыг олж мэдсэн бөгөөд энэхүү баримт яг л энэ үр дүнд хүргэх өөр нэг ажиглалттай минь яв цав нийцсэн билээ. Хоёр хөшөөн дээрх бичээсүүдийн параллель хэсгүүд дэх ижил үгсийг зөв бичих дүрмийн үүднээс харьцуулж үзэх явцад энэ бүх хэсгүүдэд адилхан мөрдөгдөж байгаа нэг зүй тогтол ажиглагдсан нь гэвэл, яг энэ гурван тэмдэг нэг бол бичигдэж, нэг бол гээгдсэн байв. Энэ үзэгдэл бусад тэмдгийн алинд нь ч ажиглагдаагүй юм. Тиймээс энэхүү гурван тэмдэг эгшиг үсгийг тэмдэглэдэг, тэгээд эгшиг үсэг нь бичигдэж ч, гээгдэж ч болдог гэдэг нь энэхүү зүй тогтлоос хийх цор ганц боломжит гаргалгаа юм.

Энэ гурван эгшиг үсгийг тэмдэглэсэн дүрс хийгээд бусад тэмдгийн (үүнээс үндэслэн тэдгээр нь гийгүүлэгчийг тэмдэглэж байна гэж үзэв) харьцааг судалж үзээд би тодорхой дүрэмд захирагддаг гэдгийг, өөрөөр хэлбэл эгшиг нь хүссэн гийгүүлэгчтэйгээ залгагдаж ордоггүй гэдгийг илрүүлсэн. Нэг талд нь байгаа **У** үсгийг яаж ч харсан у (бас ‘o’) эгшиг байв, харин нөгөө талынх нь хоёр тэмдэг гийгүүлэгч үсэгтэй илүү ойр харьцаатай. ‘У’ үсгийн хувьд гийгүүлэгчтэй төдий л ойр биш аж. Хэрэглэгдсэн байдлыг нь ажихад, **U** нь гарцаагүй ‘i’, **N**-ийг эхэндээ би ‘e’ гэж үзэж байсан ч яваандаа алдаа байсан нь мэдэгдэж, амжилттай тайлахад минь саад болж байсан тэрхүү алдааг би залруулсан билээ. Одоо энэ тэмдэг ‘ö’, ‘ü’-

⁴ Баруун тал дээрх бичээсийн эхлэл, миний “Хөх тэнгэр (kök täңri) дээр, хар газар (jaɣыз jir) доор бүтээгдэх үед хооронд нь хүний хүү бүтээгджээ” хэмээн орчуулсан 40-р мөр “Тэнгэр минь, гүн хөх тэнгэр минь! Чиний ивээл дор оршдоггүй юм гэж үгүй! Тэнгэр, хүн хоорондоо холбоотой, ертөнцийн амь нэг” хэмээх I хөшөөний хятад бичээстэй зарим талаар адилхан.

ийг тэмдэглэж байгааг мэдэх болсон бөгөөд эхэндээ би үүнийг у-г тэмдэглэсэнтэй адилаар тэмдэглэх учиртай гэж бодож байв⁵. ‘a’ эгшгийн тухайд Энэтхэгийн зарим бичигтэй адилаар тодорхой тэмдэггүй байж болох юм гэж санасан. Нэлээн хожим би ‘a’ болон ‘ä’ (e) үгийн эхэнд болон дунд бичигддэггүй, а-ийг, зарим үед ‘ä’ (e)-ийг тэмдэглэдэг, зөвхөн үгийн төгсгөлд бичигддэг **ᠠ** тэмдэг байдгийг тогтоов.

Эдгээр тэмдгийн харилцааг шинжсэний эцэст энэ дагуу гийгүүлэгчүүдийг ойлгох боломж нээгдсэн бөгөөд дагалдаж буй эгшгээс нь шалтгаалан нэг гийгүүлэгчийг өөр өөр тэмдгээр тэмдэглэдэг гэдгийг ухаарсны үндсэн дээр би энэхүү бичээсүүдийн хэл эгшиг зохицох хуульд захирагддаг гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Нэг үгийг өөр өөр янзаар бичсэн хийгээд олон тэмдгийн хэрэглээг ажиглан статистик гаргасны эцэст тэрхүү хэлний тэмдгүүдийн нэлээд нь гарвал нэгтэй гэх бодол төрсөн бөгөөд тэсрэлттэй, хамрын гийгүүлэгчийн тухай гэх мэт, нэгэнт зөвшөөрөгдсөн дүгнэлтүүдэд хүрсэн. Цаашлаад, цөөн тооны, зарим тэмдэг нь энгийн нэг гийгүүлэгч бус, давхар гийгүүлэгчийг тэмдэглэж байгаа нь илэрхий болсон билээ. Гэхдээ энэ бүгдийг дэлгэрэнгүй тайлбарлах боломж алга.

Цаашид энэ чиглэлийн судалгаанд ахиц гаргахын тулд үгсийн утгыг тайлж, хятад эхэд үзэгдэж буй оноосон нэрсийг олж тогтоох нь нэн чухал байв. Удаан хайгаад би олигтой үр дүнд хүрээгүй бөгөөд бидний онцолж байгаа бичээсүүдэд тэрхүү нэрсийн ихэнх нь огтоос байхгүй гэдгийг одоо мэдэх болсон учир гайхах зүйл үгүй. Анхнаасаа л миний анхаарал хоёр үгэн дээр голчлон хандсан юм.

Нэг нь Орхоны ч, Енисейн ч бичээсүүдэд байнга тааралдана. Заримдаа дагавар бүхий, заримдаа дагаваргүй тааралдах эл үг ихэнхдээ нүдэнд шууд тусахуйц байрлалд, эсхүл шинэ мөрийн эхэнд, эсхүл хааны хэргэм зэрэг (тэнгэрийн хаан, “Inscriptions de L’Orkhon” XXIX, XXXV)-тэй зэрэгцэж харагддаг. Тэр үг бол **ᠠᠨᠢᠭᠠᠨ**. Бас юугаараа гайхалтай санагдсан бэ гэвэл, дагавар залгагдаагүй үед миний ‘i’ эгшиг тэмдэглэгддэг гэж үзсэн тэмдгээр төгсөж байсан явдал. Энэ бүхнийг бодолцон би монгол болоод бүх түрэг хэлэнд (хувьсаж өөрчлөгдсөн, шинэ цагийн хэлбэрт нь) тэнгэр, бурхан гэх утгыг илэрхийлдэг “täŋgri” гэдэг үг байна гэж таамагласан билээ.

Миний эргэн эргэн шинжсээр ирсэн хоёр дахь үг нь I хөшөөн дээр элбэг тохиох хэр нь II хөшөөн дээр бараг байхгүй үг - **ᠨᠢᠭᠠᠨ**. Удтал эргэлзсэний эцэст би энэхүү хөшөө сүндэрлэх шалтгаан болсон эзэн ханхүүгийн бүтэн нэр гагц энэ үгэнд л нуугдаж байх боломжтой гэдэгт баг итгэх болсон юм. Бидний харсанчлан (174-р хуудас) хятад бичээст түүнийг Кюэ ти(к)-кин [K’iueh-ti(k)-k’in] хэмээн бичсэн байх ба энэ нэрийг саяхныг хүртэл түрэг хэлний Кёк-миин буюу Кёк (=цэнхэр, Шлегелийн “giogh” хэмээн оновчгүй буулгасан) ханхүү гэх үгэнд нийцнэ гэж үзэж байв. Удаан хугацаанд дээр дурдсан үгээс ханхүүгийн нэрийг олж хараагүйн шалтгаан нь нэг талаас би **ᠨ** тэмдгийг эхэндээ буруу тайлсных, гэвч түүнээс ч илүүтэйгээр **ᠮ** тэмдгийг ‘к’ гэх баталгааг өөр үгээс олж чадахгүй байсанд оршино. Жинхэнэ утгыг нь тайлахын тулд дахиад сайн ажиллах ёстой байж. **ᠮ** нь чухамдаа ‘к’ биш, харин ‘л’ (тагнайшсан) байв. Өөрөөр хэлбэл, ханхүүгийн нэр Кёк биш (энэ үг ‘к’ үсгийг тэмдэглэсэн **ᠨ** тэмдэгтэйгээр нэр үг хэлбэрээр тааралдана, 176-р хуудаснаас жишээ үзэх), Кёл эсвэл Күл-мигін юм. Хятад хэлэнд үе “л” авиагаар төгсөхгүй учир эл авиа ni-kia (pi-kia), эсвэл Шлегелийн бичсэнчлэн *niim-ka* (pit-kia, 174-р хуудаснаас харах) үгийн адилаар гээгджээ. Энэ үг нь оноосон нэр биш, жинхэнэ нэр агаад түрэгээр билгэ (**ᠨᠢᠭᠠᠨ**) буюу ухаантай гэх утгатай үг ажээ.

Энэ хоёр үг байнга таардаг **ᠠᠨᠢᠭᠠᠨ** үгийн утгыг тайлж өгсөн бөгөөд сүүлчийн тэмдэг (зүүн талд = №10, 179-р хуудаснаас харах) нь миний урьд олж мэдсэнчлэн Күл гэдэг үгийн (№9) эхний тэмдэг байв. Ингээд *mürk* (хятадаар Ту-кюэ, 174-р хуудаснаас үзэх) гэж уншигдана.

⁵ Тайлбарт дурдсан мөнхүү захидалд Радлов дээр дурдагдсан гурван тэмдгээс эгшиг олж таньсан хийгээд хоёр дахь нь i авиаг тэмдэглэдэг гэж үзсэнээ бичжээ.

Энэ дагуу хоёр хөшөөн дээрх бичээсийн хэл нь түрэг гэж тогтоосон. Түүхэн баримт, нэрс, хоёр хөшөөн дээрх хятад эх дэх үгсийг хөөвөл мөн л ийм дүгнэлтэд хүрнэ.

Өөр үгсийг энэ зарчмаар уншсаар, олон олон цэвэр түрэг үгсийг тайлсан бөгөөд тэр үгсийн ачаар нууцлаг үлдсэн тэмдгүүдийг нэг нэгээр нь нээсээр цагаан толгойг нь бүхэлд нь таньж чадсан юм. Өдгөө энэхүү бичээсүүдийн тухай мэдэж чадаагүй олон зүйлс бий ч бичээсүүдийн дийлэнхийг төвөггүй уншиж, ойлгох болсон тул өөрийн тайлалдаа эргэлзэхгүй болсон⁶.

Эхний удаад би цагаан толгойгоо танилцуулаад өндөрлөө. Эл цагаан толгой дахь авиаг би Радловын “Vergleichende Grammatik der nördlichen Türkssprachen, I, Лайпциг. 1892”-даа ашигласан системийн дагуу (тухайлбал, u=ou франц; y=заримдаг гийгүүлэгч, польш хэлний y-тай бараг адил; j=i гийгүүлэгч г.м) оруулсан болохоо цохон тэмдэглэе. Эгшгийн тухайд (дээр 176-р хуудаснаас харьцуулж харах) гэвэл энд би эгшиг гээсэн жишээ болгон өргөн хэрэглэгддэг **1** буюу alp [алп] “зоригтой” болон alyp [алып] “аваад” гэх хоршлыг онцолъё. Хоолойн эгшиг (a, o, и, мөн ихэнх тохиолдолд y)-тэй л хоршдог тэмдгийг би ¹ хэмээн тэмдэглэсэн бол зөвхөн тагнайн эгшигтэй (ä, ö, ü, i) хоршдог тэмдгийг ² хэмээн ялгав. ‘y’ эгшиг энэ хоёр ангиллын заагт хэлбэлздэг бөгөөд зарим гийгүүлэгч, нэн ялангуяа ‘j’ ба ‘s’-тэй хорших үед ихэвчлэн ² гэж тэмдэглэлээ.

⁶ Жишээ нь тэнгэрлэг хааны хэргэм зэрэг I хөшөөний 54-р мөр, II хөшөөний 77-р мөрд өөрөөр уншигддаг. Тэнгэртэй тэнгэрдэ болмыш түрк билгэ каган, үгчлэн орчуулбал “тэнгэрээс буусан тэнгэр (бурхан) лугаа адил, түрэгүүдийн ухаант хаан”. Тэгвэл II-41 ба 45-д тэнгэрдэ болмыш биш, тэнгэри жарытмыш “тэнгэрийг гэрэлтүүлэгч” гэжээ. Уйгуруудын үед хамаарах III хөшөөний нүүрэн талд мөн хааныг өөрөөр цоллосон буй (“Inscriptions de L’Orkhon”, 46-р хүснэгт=Радловын “Атлас”, хүснэгт XXXV). [б?]у тэнгэри к’н[и?] тэнгэрдэ к[у]т булмыш ¹л [n] билгэ тәһ[r]i уйгур K[аган...] буюу “тэнгэрээс аз жаргалыг олсон, тэнгэр (эсвэл бурхан)-ийн дараа (?), уйгуруудын зоригт (эсвэл өндөр дээд), ухаант хаан”. Миний тайллын талаар тэр үед мэдээгүй байсан Радлов надад илгээсэн захидалдаа мөнхүү хөшөөний уйгуруудын тухай хэсгээс хааны “тэнгэрээс аз жаргалыг олсон, ухаант, өндөр дээд хаан” гэх цолыг уншиж чадсан тухайгаа бичсэн билээ. Энэхүү мэдээлэл “аз жаргал” гэх утгатай K(y)т гэдэг үгийг буулгахад дутуу байсан нэг тэмдгийг нөхөхөд тусалсны зэрэгцээ тайлал минь зөв байсныг нотолсон, ашигтай давхцал болсон юм.

Цагаан толгойг үзүүлбэл⁷:

- | | |
|--|--|
| 1. ᠠ a, ä [a, ä] | 20. ᠨ n ¹ [n] |
| 2. ᠢ y, i [ы, i] | 21. ᠨ n ³ [n] |
| 3. ᠣ o, u [o, y] | 22. ᠮ m [m] |
| 4. ᠥ ö, ü [ö, y] | 23. ᠮ r ¹ [p] |
| 5. ᠬ q (k ¹) [k] | 24. ᠮ r ² [p] |
| 6. ᠬ q <i>у-ийн өмнө (к ы-ийн өмнө болон хойно)</i> | 25. ᠯ l ¹ [л] |
| 7. ᠬ q (<i>өмнө болон хойно</i>) o, u [k] | 26. ᠯ l ³ [l] |
| 8. ᠮ γ (g ¹) [ɣ] | 27. ᠮ j ¹ [j] |
| 9. ᠮ k (k ²) [k] | 28. ᠮ j ³ [j] |
| 10. ᠮ k <i>хойно (өмнө)</i> ö, ü [k] | 29. ᠮ -j (-ɣ) ai [j, ai, oj] |
| 11. ᠮ g (g ³) [ɣ] | 30. ᠮ s ¹ [c] |
| 12. ᠮ t ¹ [т] | 31. ᠮ s ² (s [?]) [c, ш] |
| 13. ᠮ t ² [т] | 32. ᠮ z (-s) [з] |
| 14. ᠮ d ¹ [д] | 33. ᠮ š [ш] |
| 15. ᠮ d ² [д] | 34. ᠮ č [ч] |
| 16. ᠮ p (-p) [п] | 35. ᠮ (i)č [ч, iч] |
| 17. ᠮ b ¹ (p ¹ ?) [б] | 36. ᠮ nd (nt) [нд] |
| 18. ᠮ b ² (p ² ?) [б] | 37. ᠮ nč [нч] |
| 19. ᠮ ŋ (ng) [ң] | 38. ᠮ ld (lt) [лд, ld, лг, lg] |

Хэрхэн тайлснаа энд үүнээс дэлгэрэнгүй тайлбарлах боломжгүй байна. Шулуухан хэлэхэд, энэ тайллын дагуу тэмдэг бүрийг нь миний оноосон авиагаар сольж тавибал гарч ирэх хэл л энэ судалгаанаас авч үлдэх ганц зүйл юм. Тэр нь түрэг хэлний аялгуу бөгөөд уйгур хэлтэй төгс зохицох, маш ойрын ч гэлээ ав адил биш хэл билээ. Зарим талаар бидний энэ аялгуу илүү хоцрогдмол гэж хэлж болохоор санагдана. Үүнээс гадна бидний энэ аялгуу авиаг илүү тод тодорхой илэрхийлэх боломжтойгоороо уйгур бичгээс давуу аж.

Энэхүү цагаан толгойны талаар илүү тодорхой ярих цаг ирээгүй байна. Гагцхүү зарим тэмдэг нь пехлави (дундад перс) хэлний цагаан толгойтой дүйж байгааг онцлохыг зөвшөөрнө үү.

Энэ тэмдэглэлийг одоохондоо үүгээр хязгаарлаж, тайлах ажлаа өөр газар илүү дэлгэрэнгүй тайлагнах эрхийг өөртөө үлдээе.

Вильгельм Томсен

⁷ “Оросын эзэн хааны Археологийн нийгэмлэгийн Дорно дахины салбарын тэмдэглэл”-ийг уншигчид эвтэйхэн болоосой хэмээн латин үсгийн хажууд [] тэмдэг дотор В.В.Радловын орос галигийг хавсаргалаа.